

2026 оны 6 дугаар сарын 2

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.9-д иргэн төрийн удирдлагад шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан оролцох эрхтэй, 59 дүгээр зүйлийн 59.2-т нутгийн өөрөө удирдах байгууллага нь баг, хорооны иргэдийн нийтийн хурал байна гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ”, 60 дугаар зүйлийн 60.2-т “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно” гэж заасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр Монгол Улсын Үндсэн хуулинд заасан эдгээр заалтууд хэрэгжих боломжгүй болсон байна. Үүний улмаас өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд нийслэлийн 204 хороо, аймгуудын 1647 багийн иргэдийн Нийтийн Хурал тогтмол хуралдахгүй, зарим талаар зогссон, хуралдсан зарим багт хуралдааны тогтоол гарах эсэх нь гүйцэтгэх удирдлагаас хамаарсан байдалтай байна. Тус хуулийг батлахдаа нийгмийн бодит эрэлт хэрэгцээг тодорхойлохгүйгээр нутгийн өөрийн удирдлагын чиг үүргийг гүйцэтгэх засаглалд хамааруулан гажуудал үүсгэснээс гадна хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан журам, аргачлалыг эрх бүхий байгууллагаас батлаагүйн улмаас иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрх зөрчигдсөн байна.

Нутгийн өөрөө удирдах ёсны хүрээнд Иргэдийн Нийтийн Хурал (ИНХ) нь иргэдийн шууд оролцооны үндсэн институт юм. Гэвч Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7-д “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн дараах баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдааныг сум, дүүргийн Засаг дарга шинээр томилогдсоны дараа зохион байгуулна” гэж заасан бөгөөд ИНХ-ыг хэн зарлан хуралдуулах тодорхойгүй байна. Ингэж ИНХ-ыг зохион байгуулах, хуралдуулах үйл ажиллагааг зөвхөн гүйцэтгэх засаглалын албан тушаалтны шийдвэртэй шууд

уялдуулсаны улмаас иргэдийн оролцооны эрх хязгаарлагдан, ИНХ-ын тасралтгүй ажиллагаа алдагдаж нутгийн өөрөө удирдах ёсны бие даасан шинжийг анхан шатанд сулруулах үр дагавар үүсгэжээ.

Хуулийн 32.9, 32.10 дахь заалтаар ИНХ-ыг тодорхой удирдлагын бүтэцгүй болгож, зөвхөн хуралдааны даргыг хоёр жилийн хугацаатай сонгохоор хязгаарласан нь байнгын болон түр албан тушаалыг нэг заалтаар нэгтгэсэн логикийн зөрчилтэй тул тодорхойгүй байдал үүсгэж төлөөллийн байгууллагын чадамжийг сулруулж байна. Тэр дундаа ИНХ-ыг даргагүй, тэргүүлэгчидгүй болгож иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөл байхаар шийдвэрлэсэн нь Засаг даргын эрх мэдлийг төвлөрүүлж, иргэний эрхийг хязгаарласан байна. ИНХ-ын Зөвлөлд хуралдааны дарга, Засаг дарга болон түүний томилсон хэсгийн ахлагч нарыг багтаахаар хуульчилсан нь засаглалын эрх мэдлийн хуваарилалтыг зөрчиж, ИНХ-ыг гүйцэтгэх засаглалаас хараат байдалд оруулах төдийгүй ашиг сонирхолын зөрчил үүсэх нөхцлийг бүрдүүлсэн байна. “ИНХ-ын Зөвлөлийн бүрэлдэхүүнд хэсгийн ахлагч нар орохоор заасан боловч иргэдийн төлөөлөл хэдэн хүн байхыг хуульд тодорхой заагаагүй учир энэ нь ИНХ-ын зөвлөл бус “Засаг даргын зөвлөл” болчихоод байна гэсэн шүүмжлэл гарсан” (Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцийн чадавхийг бэхжүүлэх нь” төслийн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилт, 2023).

Иймд нутгийн өөрөө удирдах ёсны институцийн тасралтгүй, тогтвортой байдлыг хангах үүднээс ИНХ-ыг зөвхөн хуралдаан даргалагч төдий бус, Хурлын бүрэн эрхийн хугацаанд үйл ажиллагааг нь нэгдсэн удирдлагаар хангах, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, иргэдийг төлөөлөх чиг үүрэг бүхий “Хурлын дарга”-тай байхаар хуульчлах шаардлагатай. Энэ нь нутгийн өөрөө удирдах байгууллагыг гүйцэтгэх засаглалын дэргэдэх түр зуурын бүтцээс ангижруулж, бие даасан засаглалын институт болгон бэхжүүлэх хууль зүйн баталгаа болно. Мөн ИНХ-ын даргын хараат бус байдал, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс түүний эдийн засгийн баталгааг хуульчлан тогтоох нь гүйцэтгэх засаглалаас хараат бус ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль зүйн чухал зохицуулалт болно.

Түүнчлэн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", түүнчлэн "Цахим үндэстэн" хөтөлбөрт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээ болон шийдвэр гаргах үйл явцыг цахимжуулах зорилтууд тусгагдсан. Хуулийн 32.2-т ИНХ-ын зохион байгуулалтын үндсэн хэлбэрийг зөвхөн хуралдаанаар хязгаарлаж, 32.4-т иргэдийг зөвхөн биечлэн ирсэн тохиолдолд оролцогчид тооцохоор заасан нь цахим шилжилт эрчимжсэн өнөөгийн нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцэхгүй бөгөөд иргэдийн оролцоог хангах орчин үеийн дижитал боломжуудыг хязгаарлах талтай байна. Цаашилбал, цахим засаглалын чиг хандлага болон орчин үеийн технологийн дэвшлийг ашиглахгүй байх нь төлөөллийн байгууллагын хүртээмжтэй байдлыг бууруулах эрсдэлтэй байна.

ИНХ хуралдахгүй байх нь зөвхөн улстөрийн бус, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсгэсэн байна. Сангийн сайдын 2021 оны 05 сарын 24-ний өдрийн 86 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д баг, хорооны түвшинд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг төлөвлөхдөө баг, хорооны иргэдийн оролцоог хангах зохицуулалтыг тусгаж өгсөн бөгөөд баг, хорооны иргэдийн

хамгийн олон санал авч эрэлмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг заавал багтаах зэрэг иргэдийн оролцоотой зайлшгүй холбогдох заалтууд тусгагдсан боловч ИНХ хуралдахгүй байгаагийн улмаас иргэд тодорхой мэдээлэл авч чадахгүй болж, журам хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсээд байна.

Эдгээрээс гадна ИНХ-ын хуралдаанаар Монгол Улсын 14 хуулийн хүрээнд холбогдох асуудлыг шийдвэрлэдэг бөгөөд ИНХ хуралдахгүй байх нь тэдгээр хуулийн хэрэгжилтийг хангахгүй байх урьдач нөхцөл болоод байна. Газрын тухай хуулийн 22, 29, 52, 53, 54 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйл, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 18, 50 дугаар зүйл, Газрын хэвлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Ойн тухай хуулийн 4, 18, 19, 21 дүгээр зүйл, Усны тухай хуулийн 14 дүгээр зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйл, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 10, 32 дугаар зүйл, Хуул тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Шилэн дансны тухай хуулийн 3, 8 дугаар зүйл, Эрүүл ахуйн тухай хуулийн 12 дугаар зүйл, Байгалийн ургамлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд баг, хорооны иргэдийн Нийтийн хурлаар шийдвэрлэх холбогдох асуудлыг тодорхойлсон заалтууд тусгагдсан байна.

Дээрх үндэслэлүүдээс үзэхэд, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйл нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг зохицуулж буй боловч бодит хэрэгцээнд нийцэхгүй, хэрэгжих боломжгүй байна. Иймд Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн иргэдийн оролцох эрхийг бодитой хангах, нутгийн өөрөө удирдах ёсны институцийг бэхжүүлэх үүднээс тус зүйл заалтыг иж бүрэн шинэчлэн найруулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

1.2. Практик шаардлага

“Транспаренси Интернэшл” олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг Авлигын хөгжлийн индексийн оноогоор 180 орноос Монгол Улс 2017 онд 36 оноо авч 103, 2018 онд 37 оноо авч 93, 2019 онд 35 оноо авч 106, 2020 онд 35 оноо авч 111, 2021 онд 35 оноо авч 110, 2022 онд 33 оноо авч 116, 2023, 2024 онд 33 оноо авч 121, 116-р байрт тус тус эрэмбэлэгджээ.

Тус олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжид Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн оноо, эрэмбэ сүүлийн жилүүдэд тогтмол буурахад нөлөөлж буй гол хүчин зүйлсэд “төрийн анхан шатны мэдээлэл хомс, нээлттэй ил тод биш, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо хангалтгүй, иргэдийн мэдэх эрхийг хангах асуудал доголдолтой” гэж тодорхойлжээ.

“Олон нийтийн мэдээлэл авах эрх, төрийн үйл ажиллагаан дахь хяналт багасахад иргэдийн төрд итгэх итгэл буурч, засаглалын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг талаар судлаачид тэмдэглэсэн байна. Энэ нь иргэдийн төрд итгэх итгэлд сөргөөр нөлөөлж, мэдээлэлгүй, эсхүл дутуу буруу мэдээлэл авснаас үүдэн төрийн үйл ажиллагаанд итгэхээ болих үр дагавар үүсгэдэг байна. Иймд төрийн байгууллага, албан хаагч өөрийн шийдвэр, үйл ажиллагааны талаарх үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээллийг олон нийттэй тогтмол хуваалцах нь төрд итгэх олон нийтийн итгэлийг

бэхжүүлэх чухал ач холбогдолтой” (Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ 2023 он, 20-21 хуудас).

“Үндэсний аюулгүй байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” олон улсын зарчимд зааснаар мэдээлэл авах эрх нь төрийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог дэмжиж, ардчилал, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгын салшгүй хэсэг болдог. Харин иргэдийн Нийтийн Хурлыг тогтмол зохион байгуулах хууль эрх зүйн үндэс байхгүйн улмаас ИНХ хуралдахгүй байгаа нь иргэд олон нийтийн Үндсэн хуулийн эрхээ эдлэх, нутгийн өөрөө удирдах ёсонд оролцох боломжийг хязгаарлаж байна”(The Global Principles on National Security and the Right to information (The Tshwane Principles) 2013).

2022 оны 01 сарын 01-ний өдрөөс хэрэгжсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн ИНХ-ын зохион байгуулалттай холбоотой заалтууд хязгаарлагдмал байгаа нь нутгийн өөрөө удирдах анхан шатны байгууллагын эрх зүйн тогтолцооны системчлэлийг агдагдуулж иргэдийн хууль ёсны эрх ашиг зөрчигдөх нөхцлийг бүрдүүлэн, хорооны ИНХ-ын үйл ажиллагааг доголдуулж байгааг олон судалгаа харуулж байна. Тус хууль нь бодит нөхцөл байдалтай нийцэхгүй байгаагийн улмаас шинэчлэн зохицуулах дараах практик шаардлага үүссэн байна.

1. Засаглалын шаардлага

ИНХ нь тухайн баг, хорооны иргэдийн хүсэл зоригийг илэрхийлэх, шийдвэр гаргах дээд байгууллага бол Засаг дарга нь ИНХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн биелэлтийг хангах чиг үүрэг бүхий томилогдсон албан тушаалтан. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнээс хойш баг, хороодын Иргэдийн Нийтийн Хурал доголдсон, Засаг даргын үүрэг гүйцэтгэгч нар ажиллаж, хуулийг зөрчсөөр байна. Зарим баг, хороонд Засаг даргын санаачилгаар ИНХ-ыг хуралдуулсан боловч ИНХ-ын тогтоолд Засаг дарга гарын үсэг зурж, тогтоолыг баталсан нь нутгийн өөрөө удирдах ёсонд үл нийцэж байна.

Засаг дарга нь шийдвэр гаргах түвшний ИНХ-ын тогтоолд гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь хянагч өөрөө гүйцэтгэгч болж ашиг сонирхлын зөрчил үүсгэж байгаагаас гадна иргэний хяналтын тогтолцоог алдагдуулж байна. ИНХ-д ажлаа тайлагнах үүрэг бүхий Засаг дарга эрх мэдлийн хяналт-тэнцвэрийг алдагдуулж, Хурлын шийдвэрт шууд нөлөөлөх болсон нь ИНХ-ыг гүйцэтгэх засаглалын шийдвэрийг хэлбэр төдий баталгаажуулдаг байгууллага болгон хувиргаж байна. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх мэдлийг ганц хүн төвлөрүүлэн хэрэгжүүлж буй энэхүү хууль бус үйлдэл нь шийдвэрийн эрх зүйн чадамжийг үгүйсгэх, хариуцлагын тогтолцоог сулруулах, төрийн институцид итгэх иргэдийн итгэлийг алдагдуулах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй юм.

Тиймээс баг, хорооны ИНХ-ын дарга, Засаг даргын үйл ажиллагааг зааглаж, нутгийн өөрөө удирдах байгууллага нь гүйцэтгэх засаглалаас хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх нь засаглалыг сайжруулах боломжтой юм. Үүний тулд ИНХ-ын дарга, тэргүүлэгчдийг бие даасан үйл ажиллагаатайгаар зохицуулалтыг хуулинд тусгаж, дарга, тэргүүлэгчийг иргэдийн санал хураалтаар өрсөлдүүлэн сонгодог зохицуулалттай байх практик шаардлага үүссэн байна.

2. Хүн амын төвлөрөл, хотын засаглалын хэрэгцээ

Улаанбаатар хотын хамгийн их хүн амтай хороо 32000 хүн амтай, дундаж хороод 15,000-20,000 хүн амтай байна. Хүн амын төвлөрөл нэмэгдэхийн хэрээр хог хаягдал, орчны аюулгүй байдал, газар олголт зэрэг тулгамдсан асуудал өдөр бүр үүсдэг. ИНХ тогтмол хуралдахгүй байгаагаас иргэд амьдарч буй орчныхоо асуудалд шууд нөлөөлөх боломжгүй болж, орон нутгийн удирдлага иргэдээсээ тасарсан байна.

Ялангуяа нийслэлийн хороодын хэмжээнд иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагаа доголджээ. Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирүүлсэн мэдээлэлд дурдсанаар "2025 онд 1647 баг, 204 хорооны ИНХ 4188 удаа хуралдаж 12500 асуудал хэлэлцэж 8721 тогтоол гаргасан. Үүнээс нийслэлийн 9 дүүргийн 204 хорооноос 2025 онд 145 удаа хуралдсан бол Баянзүрх, Багануур, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн ИНХ зохион байгуулагдаагүй байна. Баянзүрх, Багануур, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн хороодын иргэдийн Нийтийн Хурал хуралдаж чадаагүй нь хуульд заасан ирцийг бүрдүүлэхэд бодит байдалд хүндрэлтэй байхаас гадна иргэд биечлэн хуралд оролцох эрх зүйн орчин үйлчилж байгаа төдийгүй дүүргийн хүн ам, оршин суугчдын тоо хэт өндөр байгаатай холбоотой байна. Мөн хурлын талаарх мэдээлэл иргэдэд цаг тухайд нь хүрдэггүй зохион байгуулалтын доголдол, түүнчлэн ажил, амжиргааны нөхцөлтэй уялдахгүй хурлын зохион байгуулалт зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг байна" (Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын мэдээлэл. 2026.05.08).

ИНХ-ын хуралдаан хуралдахгүй байгаа нь иргэдийн төлөвлөх болон оролцох эрхийг хязгаарлаж байна. Засаг даргын үзэмжээр хурлыг гэнэт зарладаг эсвэл огт хуралдуулдаггүй байдлыг зогсоохын тулд жилийн эхэнд "Хурлын цаглабар"-ыг баталж, иргэд асуудлаа бэлтгэх, төлөвлөх боломжоор хангах практик шаардлага үүссэн байна. Дээрх тоо баримт нь хотын засаг захиргааны анхан шатны нэгжид нутгийн өөрөө удирдах ёс бүрэн алдагдаж, засаглалын гүн хямрал нүүрлэснийг илтгэж байна. Иймд хүн амын хэт төвлөрөлтэй нийслэлийн хороодын онцлогт тохирсон ирцийн шатлалт босго тогтоох, хуралдааныг цахим хэлбэрт шилжүүлэх эрх зүйн зохицуулалтыг энэхүү хуулийн төслөөр зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай байна.

3. ИНХ-ын ирц, цахим шийдэл

Одоогийн практикт ИНХ-ын хуралдааны ирцийг бүрдүүлэхэд "өрхийн квот"-оор зохицуулж байгаа нь иргэдийн оролцоог хангах биш, харин бусдыг оролцуулахгүй байх "хаалт" болж байна. Хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-д заасан өрхийн квотын ирц бүрдмэгц хурлын танхимын хаалгыг хаах, танил тал болон хамаарал бүхий этгээдээр ирц бүрдүүлж "гарын үсэг зуруулах" байдлаар хууль ёсны мэт харагдуулах "хэлбэрдэлт" түгээмэл байна. Хуулийн энэ зохицуулалт нь ирц бүрдүүлэхэд бус, квот тогтооход чиглэсэн гажуудал үүсгэж байгаа тул иргэдийн оролцоог сайжруулахын тулд хурлыг урьдчилан нээлттэй зарлах, мэдээллийн хүртээмжийг сайжруулахаас гадна өрхийн квотоор бус, хүн амын тооноос хамааруулан ирцийн босго тогтоож, иргэдийн төлөөллийг хангах, нээлттэй хуралдаан явуулах шаардлага үүсгэж байна.

Мөн хөдөлмөрийн насныхан өглөөний 08:00 цагаас оройны 18:00 цаг хүртэл ажилтай байдаг тул ажлын өдөр, цагаар зарлагдсан ИНХ-д биечлэн (танхимаар) очиж оролцох боломжгүй байдаг. Энэхүү бодит саад бэрхшээл нь тэднийг амьдарч буй

орчных нь асуудлаас хөндийрүүлж байна. Тиймээс иргэдийг заавал нэг зааланд цуглуулах гэж шаардах бус, байгаа газраасаа ухаалаг утас, интернэт ашиглан хуралдаа оролцох нөхцөлийг бүрдүүлэх практик шаардлага тулгарч байна. Хуулиар ИНХ-д цахим платформуор (Zoom, тусгай аппликейшн, e-mongolia гэх мэт) холбогдож, оролцох эрхийг нээвэл залуучууд гар утаснаасаа, гэрээсээ эсвэл ажлаасаа амьдарч буй орчныхоо асуудалд шууд мэдээлэл авах, хяналт тавих бодит боломж нээгдэнэ.

4. Засаг даргыг сонгох эрхийн тэгш байдал

Баг, хорооны Засаг даргыг нэр дэвшүүлэх санал хураалтыг зөвхөн хурлын танхимд байгаа цөөн хэдэн хүний “гар өргөлтөөр” хязгаарлах бус, тухайн нэгжийн нийт иргэдэд нээлттэй, бүтэн өдрийн турш нууцаар санал өгөх боломжийг бүрдүүлснээр иргэдийн засаглах эрх бодитой хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Энэ нь сонгуулийн насны иргэдийн идэвхийг нэмэгдүүлж, нэр дэвшигчийн олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх легитим шинжийг баталгаажуулах ач холбогдолтой.

Иймд иргэдийн Нийтийн Хурлыг тогтмолжуулах, зохион байгуулалтын хэлбэрийг бодит нөхцөл байдлын шаардлагад нийцүүлэх, Засаг даргын оролцоог хязгаарлаж Хурлын бие даасан байдлыг хангах нь зөвхөн хуулийн зохицуулалт төдий биш, Монгол Улсын ардчилсан ёс, нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх практик шаардлага болж байна. Дээрх үндэслэлүүд нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чадамжийг сайжруулах, иргэдийн хяналтыг бодитой болгох, авлигаас ангид анхан шатны нэгжийг төлөвшүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэчлэл хэрэгтэй байгааг харуулж байна.

Хоёр: Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийг шинэчлэн найруулсан төслийг бэлтгэв. 32 дугаар зүйлийн шинэчилсэн найруулгад:

1. ИНХ-ын үйл ажиллагаа,
2. ИНХ-ын бүрэн эрх,
3. ИНХ-ын дотоод бүтэц, удирдлага
4. ИНХ-ын зохион байгуулалт
5. ИНХ-аас Засаг даргыг нэр дэвшүүлэх зохицуулалтуудыг тусгалаа.

Энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийг шинэчлэн найруулж, иргэдийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх, баг, хорооны түвшинд шууд ардчиллыг бодитой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн төрийн удирдлагад оролцох эрхийг бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн. Тодруулбал, иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг илүү нээлттэй, хүртээмжтэй, гүйцэтгэх засаглалаас хараат бус, бие даасан хэлбэрээр явуулах эрх

зүйн орчинг бүрдүүлж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог ханган, ил тод байдал, хариуцлага, хяналтын тогтолцоог сайжруулах зорилготой.

Төсөл нь дараах тодорхой харилцааг зохицуулна:

ИНХ-ын үйл ажиллагааг цахимаар болон хосолсон хэлбэрээр зохион байгуулж, тухайн хорооны иргэд хуралдаанд чөлөөтэй оролцох, санал өгөх эрхийг нээлттэй болгох эрх зүйн үндсийг тодорхойлсон.

Сонгуулийн насны иргэд аливаа хязгаарлалтгүйгээр иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд оролцох, хэлэлцэх асуудал санаачлах, санал өгөх, нэр дэвших, дэвшүүлэх болон хурлын шийдвэрийг тайлбарлах зэрэг эрх, үүргийг нарийвчлан заасан.

Нутаг дэвсгэрийн хүн амын нягтаршил нь газар зүйн байршил, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан харилцан адилгүй тул ИНХ-ын хуралдааны ирцийг сонгуулийн насны иргэдийн тоотой уялдуулан, шатлалтай зохицуулахаар тусгасан болно. Төсөлд сонгуулийн эрх бүхий 500 хүртэлх иргэнтэй баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд нийт иргэдийн 10-аас доошгүй хувь нь оролцсон тохиолдолд, 501-3000 хүртэл сонгогчтой бол нийт сонгогчдын 5-аас доошгүй хувь, 3001-6000 сонгогчтой бол нийт сонгогчдын 3-аас доошгүй хувь оролцсон тохиолдолд, 6,001-аас дээш бол ирцийг 250-аас доошгүй иргэн оролцсоноор хүчин төгөлдөрт тооцох бөгөөд үүнд тухайн баг, хорооны нийт хэсгүүдийн төлөөлөл жигд хангагдсан байхаар тусгалаа.

ИНХ нь даргатай болсноор ИНХ-ыг зарлах, хуралдуулах, даргалах, хурлын шийдвэрийг баталгаажуулах, үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах үүрэгтэй байна. Ингэснээр гүйцэтгэх удирдлага болох хорооны Засаг дарга нь ИНХ-ын үйл ажиллагаанд оролцохгүй, иргэдийн төлөөллийн байгууллагын бие даасан байдлыг хангах эрх зүйн орчин бүрдэнэ. ИНХ нь 5-11 гишүүн бүхий тэргүүлэгчтэй байх бөгөөд тэргүүлэгч нь хуралдааны чөлөөт цагт зохион байгуулалт, хяналтын ажлыг гүйцэтгэх чиг үүрэгтэй байхаар зохицуулсан болно. ИНХ-ын хуралдааны цаглаварыг жил бүрийн эхний сард батлан, олон нийтэд нээлттэй танилцуулж, ил тод байдлыг хангахаар зохицууллаа.

Баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх ажиллагааг ил тод, чөлөөтэй, тэгш боломжоор хангагдсан санал хураалтын зарчимд үндэслэн зохион байгуулж, иргэдийн Нийтийн Хурлаар нээлттэй хэлэлцэх, тухайн баг, хороонд бүртгэлтэй, сонгуулийн насны иргэд санал өгөх эрхтэй байх зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн тус хуулийн 56.4.1-д хорооны Засаг даргад нэр дэвшигч нь дээд боловсролтой байх, багийн Засаг дарга нь бүрэн дундаас дээш боловсролтой байх шаардлага тавьсан нь ижил түвшний засаг захиргааны анхан шатны нэгжийг удирдаж буй этгээдүүдэд боловсролоор нь ялгавартай хандсан тул Үндсэн хуулийн суурь зарчимтай зөрчилдөж байна. Монгол Улсын иргэн нь иргэний эрхээ нутаг дэвсгэрийн байршлаас үл хамааран ижил түвшинд баталгаажуулах эрхтэй. Үүнээс гадна баг,

хорооны түвшинд дээд боловсролтой хүний нөөцийн хүрэлцээгүй байдлын улмаас бодит байдалтай нийцэхгүй байна. Иймд баг, хорооны Засаг даргад нэр дэвшигчийг бүрэн дундаас дээш боловсролтой байхаар өөрчлөлт оруулахаар тусгалаа.

32 дугаар зүйлийг өөрчлөн найруулсантай холбогдуулан 56 дугаар зүйлийн 56.5-ын 56.5.1, 56.5.2 дахь хэсгүүдэд баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлэхдээ бүрэн дундаас дээш боловсролтой, иргэдийн Нийтийн Хурлын санал хураалтаар хамгийн олон санал авсан хүнийг нэр дэвшүүлэх зохицуулалтыг оруулсан болно.

Энэхүү хуулийн төсөл нь дараах нэгжүүдийг хамарна:

- Нэгжийн түвшинд: Монгол Улсын засаг захиргааны хамгийн анхан шатны нэгж болох баг болон хороо.
- Иргэдийн түвшинд: Тухайн баг, хороонд бүртгэлтэй, сонгуулийн насны бүх иргэд.
- Байгууллагын түвшинд: Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, түүний дарга болон тухайн шатны Засаг дарга нарын эрх хэмжээг хамран зохицуулж байна.

Гурав. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар:

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн хамгийн анхан шатны нэгж болох баг, хорооны түвшинд дараах үр дагавар бий болохоор байна:

1. Нийгмийн үр дагавар

- Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал (ИНХ) нь шууд ардчиллын үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага болох нь хуульчлагдана.
- Сонгуулийн насны иргэн аливаа хязгаарлалтгүйгээр хуралд оролцох, асуудал санаачлах, санал өгөх, нэр дэвших эрхтэй болсноор иргэдийн нийгмийн идэвх сэргэнэ.
- Хүн амын тооноос хамаарч ирцийн босгыг ялгавартай (10%, 5%, 3% эсвэл 250-аас доошгүй хүн) тогтоосон нь жижиг багуудад ч, том хороодод ч иргэдийн дуу хоолой төрийн шийдвэрт хүрэх боломжийг тэгш олгоно.
- ИНХ нь Хурлын даргатай болж нутгийн өөрөө удирдах ёсны үйл ажиллагаа анхан шатанд тогтмолжиж бэхжинэ.

2. Хууль зүйн үр дагавар

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйл бүхэлдээ шинэчлэгдэж, илүү нарийвчилсан зохицуулалттай болно.
- Хуралдааныг танхимаар, цахимаар болон хосолсон хэлбэрээр зохион байгуулж болохоор хуульчилсан нь орчин үеийн технологийн дэвшлийг төрийн удирдлагад ашиглах эрх зүйн үндэс болно.

- Ирцийн босгыг тодорхой хувь болон тоогоор тогтоож өгснөөр ИНХ-ын шийдвэрүүд маргаангүй, хүчин төгөлдөр хэрэгжих нөхцөл бүрдэнэ.
- Үндсэн хуулиар олгогдсон иргэний эрхийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдэнэ.

3. Эдийн засгийн үр дагавар

- Иргэдийн Нийтийн Хурал нь орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлдэг тул иргэдийн бодит оролцоотойгоор батлагдсан орон нутгийн төсөв, төслүүд илүү оновчтой, үр ашигтай байх болно.
- Цахим болон хосолсон хэлбэрээр хуралдах нь иргэдийн цаг завьг хэмнэхээс гадна хурлын танхим түрээслэх, иргэдийг цуглуулахтай холбоотой зарим зардлыг бууруулах боломжтой.

Энэхүү төсөл батлагдсанаар баг, хорооны түвшинд нутгийн өөрөө удирдах ёс шинэ шатанд гарч, иргэн төвтэй засаглал бэхжих ач холбогдолтой юм.

Дөрөв. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт орох хуулиуд:

Энэхүү хуулийн төсөл нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын (ИНХ) бүтэц, ирц, оролцоог сууриар нь шинэчилж байгаа тул хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааны санхүүжилтийг баталгаажуулах зорилгоор Төсвийн тухай хуульд нэмэлт оруулна.

Ингэснээр хууль хоорондын зөрчил арилж, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын санхүү, зохион байгуулалтын хараат бус байдал хангагдана.

-----oOo-----